

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 13.320

Дохиолол ба анхааруулгын тогтолцоо. Аюулгүй байдлын тэмдэг ба дохионы өнгө	MNS 4643 : xxxx
Signal and warning system. Safety symbols and warning color	MNS 4643 : 2000-ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь аюулгүй байдлын бүх төрлийн тэмдэгтүүдийн ангилал, хэрэглэх хүрээ, өнгө тэмдэглэгээ, зориулалт, хэлбэр хэмжээ, тэдгээрт тавигдах техникийн шаардлагыг тогтооно.

Мөн аюултай, хортой хүчин зүйл бүхий орчинд үүсч болзошгүй аюулыг урьдчилан сануулах, анхааруулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор тодорхой үйлдлийг гүйцэтгэхийг заах, хориглох болон шаардлагатай мэдээллийг өгөхөд зориулагдана.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэ стандартад дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

3.2

4 Ерөнхий зүйл

4.1 Зорилго

Энэхүү стандарт нь аюулгүй байдлын тэмдэг, дохионы өнгөний нэгтгэсэн шаардлагыг тогтоож, үйлдвэрлэл, үйлчилгээ болон олон нийтийн бүхий л орчинд хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах эрсдлийг бууруулах, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.

4.2 Ерөнхий зарчим

4.2.1 Аюулгүй байдлын тэмдэгтүүд нь тухайн орчинд үүсч болзошгүй аюулыг урьдчилан ойлгуулах, аюулгүй байдлын тодорхой үйлдэл гүйцэтгэхийг зааж зөвшөөрөх, шаардлагатай мэдээлэл өгөхөд зориулагдана.

4.2.2 Аюулгүй байдлын тэмдэгийг хэрэглэж мөрдүүлэх нь аюулгүй байдлын талаар

заавал хэрэгжүүлэх шаардлага болно.

- 4.2.3 Аюулгүй байдлын тэмдэгийг хүмүүсийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй ажил үйлчилгээний байр, зам талбай, байгууламж, олон нийтийн газар мөн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав баглаанд байрлуулна.
- 4.2.4 Ажлын байр, барилгын объект болон үйлдвэрлэлийн талбайд орох хаалганд аюулгүй байдлын холбогдох тэмдэгийг байрлуулсан байвал тухайн байр, объект, талбайг бүхэлдээ энэ тэмдэгийн үйлчлэх бүсэнд хамаарагдана гэж үзнэ. Тэмдэгийн үйлчлэх бүсийг хязгаарлах тохиолдолд тайлбар заалтыг нэмж оруулсан байна.
- 4.2.5 Энэхүү стандартаар тогтоосон аюулгүй байдлын зарим тэмдэгийг замын тэмдэг, тэмдэглэлтэй хамт хоршин хэрэглэж болно.
- 4.2.6 Аюулгүй байдлын тэмдэг нь хүмүүсийн харааны түвшинд тохирсон байрлалд тод содон харагдахуйц газар хүмүүсийн анхаарлыг сарниулахааргүй, аюул үүсгэхээргүйгээр байрласан байна.
- 4.2.7 Аюулгүй байдлын эдгээр тэмдэгтүүдийг Монгол улсын бүх байгууллага, аж ахуйн нэгж, салбар (аж үйлдвэр, тээвэр, худалдаа, эрүүл ахуй, үйлчилгээ, хөдөө аж ахуй, төр захиргааны г.м) үйл байдлынхаа онцлогт нийцүүлэн сонгон хэрэглэнэ.
- 4.2.8 Аюулгүй байдлын тэмдэгтүүдийг байрлуулах газар, өндөрийн хэмжээ, тэдгээрийн хэмжээ, хувилбар, тоог тухайн байгууллагын удирдлага, галын болон хөдөлмөр хамгааллын мэргэжилтэн, эрүүл ахуйч эмч нар харилцан зөвшөөрөлцсөний үндсэн дээр тогтооно.
- 4.2.9 Аюул бүхий ажлын түр хугацааны байр, хэсэгт аюулгүй байдлын зөөврийн тэмдэг, дохиог байрлуулж ажиллана.



5 Аюулгүй байдлын тэмдэгтүүд, хэлбэр, өнгө, хэмжээ болон зориулалт

- 5.1 Аюулгүй байдлын тэмдэгтүүдийг 1-р хүснэгтэд заасан үндсэн дөрвөн бүлэгт ангилна.

Хүснэгт 1

Аюулгүй байдлын тэмдэгтүүдийн үндсэн ангилал

№	Тэмдэгийн нэр	Тэмдэгийн хэлбэр	Тайлбар
1	Хориглох тэмдэг		Тодорхой үйлдэл хийхийг хориглоно.
2	Анхааруулах тэмдэг		Аюул учруулж болзошгүй үйлдлээс урьдчилан анхааруулах
3	Сануулах тэмдэг		Хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлага хангаж тодорхой үйлдэл хийхийг сануулах

4			Галын унтраах хэрэгслийн объект, түүнд хүрэх чиглэлийг заах
	Заах тэмдэг		Эмнэлэгийн анхан шатны тусламжийн объект, түүнд хүрэх чиглэлийг заах
			Аваарийн гарц, цугларах байр түүнд хүрэх чиглэлийг заах

- 5.2 Аюулгүй байдлын тэмдэгтүүдийн үйлчлэлийг тодотгох, хязгаарлах буюу хүчтэй болгох шаардлагатай тохиолдолд тэгш өнцөгт хэлбэртэй нэмэлт хүснэгт хэрэглэхийг зөвшөөрнө.
- 5.3 Нэмэлт хүснэгтийг аюулгүй байдлын тэмдэгийн доод буюу баруун талд хэвтээгээрээ байрлуулна. Нэмэлт хүснэгтийн урт нь аюулгүй байдлын тэмдэгийн тухайн тал буюу диаметрээс илүүгүй байвал зохино.
- 5.4 Аюулгүй байдлын тэмдэг, үндсэн ба тодруулах хүрээ болон нэмэлт хүснэгтийн хэмжээг байрлуулах газар, зайнаас хамааруулан 2-р хүснэгтээр тогтооно.

Хүснэгт 2

Аюулгүй байдлын тэмдэгийн үндсэн ба тодруулах хүрээ болон нэмэлт хүснэгтийн хэмжээ

№	Аюулгүй байдлын тэмдэг, түүнийг харагч хоорондын зай /м/	6 хүртэл	6-10 хүртэл	10-20 хүртэл	20-40 хүртэл	40-50 хүртэл
1	Хориглох тэмдэг /гадна талын тойргийн диаметр/ мм	140	180	280	360	560
2	Анхааруулах тэмдэг /гурвалжны гадна тал/ мм	160	200	320	400	650
3	Сануулах тэмдэг /гадна талын тойргийн диаметр/ мм	140	180	280	360	560
4	Заах тэмдэг /тэгш өнцөгтийн талууд/	150	190	300	380	600
5	Үндсэн хүрээний өргөн мм	3,5	4,5	7	9	14
6	Тодруулах хүрээний өргөн мм	1,17	1,5	2,34	3	4,6
7	Нэмэлт хүснэгтүүдийн хэмжээ мм	140x50 150x60	180x70 190x70	280x100 300x110	360x120 380x130	560x170 600x200

		160x60	200x80	320x110	400x140	650x220
--	--	--------	--------	---------	---------	---------

Тайлбар:

1. Анхааруулах тэмдэгийн хувьд гурвалжны талууд нь цэвэр хэмжээгээр өгөгдсөн ба өнцгүүдийн дугуйралтын радиусын хэмжээ нь гурвалжны талын 0,04-тэй тэнцүү байна.
 2. Тайлбар бичиглэлийн мөрийн тооноос хамааруулан нэмэлт хүснэгтийн өндрийн хэмжээг ихэсгэж болно.
 3. Тэмдэгтүүдийн үндсэн хүрээний өргөн нь талуудын болон диаметрийн 0,025-тай тэнцүү бөгөөд тодруулах хүрээ нь үндсэн хүрээний өргөнөөс 3 дахин бага байна.
 4. 2-р хүснэгтэд заагдсан хэмжээнээс илүү том хэмжээний тэмдэгтүүдийг хэрэглэж болох бөгөөд тэдгээрийн хэмжээний хоорондох харьцаа нь шууд пропорциональ байх ёстой.
- 5.5 Үйлдвэрийн тоног төхөөрөмжид зориулагдсан аюулгүй байдлын хориглох, анхааруулах тэмдэгийн хэмжээг 3-р хүснэгтээр тогтооно.

Хүснэгт 3

**Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжид зориулагдсан аюулгүй байдлын
хориглох, анхааруулах тэмдэгийн хэмжээ**

№	Тоног төхөөрөмжид зориулагдсан тэмдэгтүүдийн	Тоног төхөөрөмжид зориулагдсан тэмдэгтүүдийг хэмжээний дугаар					
	Хэмжээ	1	2	3	4	5	6
1	Гадна талын диаметр /мм/	20	30	40	60	80	120
2	Гурвалжны тал /мм/	25	40	50	80	100	160

- 5.6 Аюулгүй байдлын тэмдэгтүүдийн дүрс, илэрхийлэл, код, хэрэглэх хүрээ, байрлуулах газрыг 4-р хүснэгтээр тодорхойлно.

Хүснэгт 4**Аюулгүй байдлын тэмдэгүүд**


Код	Тэмдэгийн илэрхийлэл	Тэмдэг	Байрлуулах газар
Нэг		ХОРИГЛОХТЭМДЭГ	
X01	Тамхи татахыг хориглоно.		Тамхи татахыг хориглосон ажил, үйлчилгээний өрөө тасалгаа, хонгил, агуулах, талбай, олон нийтийн газарт
X02	Гал гаргахыг хориглоно.		Гал, тэсрэлтийн аюултай материал, бодис хадгалах агуулах тээврийн хэрэгслийн дотор ба гадна талд
X03	Явган зорчихыг хориглоно.		Явган явахад аюултай байгууламж зам, талбайн тусгаарласан зааг, орцны гадна талд






X04	Усаар унтраахыг хориглоно.		Гарсан галыг ус хэрэглэн унтрааж болохгүй бодис, цахилгаан тоног төхөөрөмж, самбар дээр
X05	Ус уухыг хориглоно.		Ундны зориулалтын бус усны эх үүсвэр, крант, устай савны дэргэд
X06	Орохыг хориглоно.		Тусгай зориулалтын ажлын байр, талбай, агуулахын хаалганы гадна ба аюултай бүсийн зааг дээр
X07	Хөдөлгөөнт механизмаар ачаа зөөхийг хориглоно.		Амархан гэмтэх бараа материал агуулсан агуулах, ачих механизмаар зөөхөд осол гарч болзошгүй агуулах, байранд
X08	Бээлийгүй гараар авахыг хориглоно.		Хамгаалах бээлийгүй ажиллахыг хориглосон байранд, хорт бодис, халуун үйлдвэрлэл, үйлчилгээний ажлын байр талбайд, тоног төхөөрөмжийн дэргэд
X09	Хамгаалалтын бээлийгүй ажиллахыг хориглоно.		Хүчдэлтэй самбар, хувиарлах байгууламж, дэд станцын байранд нүдэнд харагдахуйц газарт байрлуулна.
X10	Залгахыг хориглоно.		Сэлгэн залгагч болон аваарийн залгуурын дэргэд
X11	Энд ачаа тавихыг хориглоно.		Аваарын гарц, хонгил, галын машин явах зам, нүүлгэн шилжүүлэх, цугларах байр, талбайд
X12	Гэрийн тэжээвэр амьтанг авч явахыг хориглоно.		Гэрийн тэжээмэл амьтад авч явахыг хориглосон ажлын байр, нийтийн тээврийн хэрэгсэл, эмнэлэг, сургууль, үйлчилгээний газар г.м.
X14	Хориглоно.		Аюултай байр, талбай, бүсэд орох орцны гадна талд
X15	Энд хог хаяхыг хориглоно.		Хог хаяхыг хориглосон байр, талбай, бүс, дархан цаазтай газар, олон нийтийн газар гэх мэт.
X16	Фото зураг авахыг хориглоно.		Музей, театр, улсын нууцын зэрэглэлд багтсан объектууд гэх мэт.


X17	Богино долгионы радио станц хэрэглэхийг хориглоно.		Эмнэлэг, ясли цэцэрлэг, радио нэвтрүүлгийн газар
Хоёр		АНХААРУУЛАХ ТЭМДЭГ	
A01	Аюултай орчин		Бүхэлдээ аюул осол учирч болох ажлын байр, талбайн орцны дэргэд
A02	Галын аюултай		Амархан авалцан шатах шингэн, хий, материалын сав баглаан дээр буюу тэдгээрийг агуулж буй агуулахын дотор, талбай, орцны гадна
A03	Тэсрэх аюултай		Тэсрэх аюултай хий, шингэний даралтат саван дээр болон тэсрэх бодисын сав баглаа болон тэдгээрийг хадгалж буй байр агуулах талбайн гадна дотно талд
A04	Хортой бодис		Хүний амь бие, эрүүл мэндэд хортой бодисын сав баглаа болон тэдгээрийн хадгалж буй байр, агуулах, лабораторийн дорто, гадна
A05	Идэмхий шүлт		Идэмхий шүлттэй ажилладаг ажлын байр, лаборатори ба тэдгээрийг хадгалдаг байр агуулахын дотор талд
A06	Даралттай сав		Хий шингэний даралтат сав, баллон хадгалдаг агуулах, талбайд
A07	Ачаа өргөх талбай		Өргөгч механизм ажиллаж буй ажлын байр, талбайд
A08	Тахир дутуу хүмүүсийн явах зориулалтын зам		Тахир дутуу хүмүүсийг явахад зориулагдсан тусгай замтай үйлчилгээний болон олон нийтийн газарт
A09	Хүчдэлтэй		110 Вольтоос дээш хүчдэлээр ажилладаг цахилгаан тоног төхөөрөмж, аппаратур болон дэд станц, хувиарлах болон хүчний самбар, тэдгээрийг агуулдаг объектийн гадна талд
A10	Хальтиргаатай газар		Хүмүүс хальтирч болох ажлын байр талбайд

A11	Бүдрэхээс болгоомжил		Хүмүүс бүдэрч болох ажлын байр, талбайд
A12	Унахаас болгоомжил		Хүмүүс унаж болох өндөрлөг ажлын байр, тавцан, талбайд
A13	Галын аюултай бодис тээвэрлэж байна.		Гал гаргах аюултай хий, шингэнийг тээвэрлэх зориулалттай сав баглаа, цистерн дээр
A14	Биохимийн хортой бодис		Төрөл бүрийн биохимийн хортой бодис хадгалдаг, үйлдвэрлэдэг байр талбай болон тэдгээрийг хадгалдаг сав баглаан дээр
A15	Хүйтэн орчин		Хөргүүртэй зоорь, агуулах, чингэлэгийн хаалган дээр
A16	Автомат ажиллагаатай		Бүрэн ба хагас автомат ажиллагаатай суурь машин, тоног төхөөрөмж дээр болон тэдгээрийн оршин байгаа байр, талбайд
A17	Аккумуляторын хүчилээс болгоомжил		Аккумулятор засварын өрөөний дотор ба гадна талд
A18	Суурь машины ирнээс болгоомжил		Төрөл бүрийн металл, модон эд анги боловсруулах суурь машин төхөөрөмжийн дэргэд
A19	Цацраг идэвхит орчин		Цацраг идэвхит бодисын сав баглаа, тэдгээрийг ашигладаг тоног төхөөрөмж болон ажлын байр, талбайн гадна дотно талд
A20	Дуу чимээтэй орчин		Хэвийн хэмжээнээс их дуу чимээтэй орчин, ажлын байрны гадна дотно талд
A21	Хүчтэй цахилгаан соронзон оронтой орчин		Хүчтэй цахилгаан соронзон орон үүсгэдэг машин механизм ажилладаг ажлын байранд

A22	Автомат хаалт		Автомат хаалга ашигладаг ажил, үйлчилгээний байрны дэргэд
A23	Дээрээс юм унаж болзошгүй орчин		Барьж байгаа барилга болон засвар хийж байгаа, хийх шаардлагатай барилга, дээрээс юм унаж болзошгүй орчин, ажлын байрны гадна дотно талд
A12	Унахаас болгоомжил		Хүмүүс унаж болох өндөрлөг ажлын байр, тавцан, талбайд
Гурав		САНУУЛАХ ТЭМДЭГ	
C01	Ерөнхий сануулах тэмдэг (Тусгай нэмэлт тэмдэгтэй хамт хэрэглэнэ)		Хүний амь нас, эрүүл мэндэд хор учруулж болох орчинд тухайн аюулыг тодотгосон нэмэлт тэмдгийн хамт хэрэглэнэ.
C02	Чихэвч хэрэглэ		Хэт их дуу чимээтэй орчин, ажлын байранд
C03	Нүүрний хамгаалалт хэрэглэ		Нүүр нүдэнд гэмтэл учруулж болох (зүсэх огтлох суурь машин, гагнуурын аппарат г.м) механизм ажиллаж байгаа ажлын байранд
C04	Ажлын гутал өмс		Ус чийгтэй, механик, дулаан, химийн бодисын үйлчлэлээр хөл гэмтэж болох ажлын байр талбайд
C05	Хамгаалалтын малгай өмс		Барьж байгаа барилга болон засвар хийж байгаа, хийх шаардлагатай барилга, дээрээс юм унаж болзошгүй орчин, ажлын байрны гадна дотно талд
C06	Хамгаалах бүстэй ажилла		Барилгын гадна талд ажиллах, өндөр хүчдэл, холбооны шугам татах үед хэрэглэнэ.
C07	Ажлын хувцастай ажилла		Тусгайзориулалтын хувцас шаарддаг ажлын байр талбайд
C08	Хамгаалалтын бээлий өмс		Хүчил, шүлт, дулаан, цахилгаан болон химийн хорт бодисын нөлөөгөөр гар гэмтэж болох ажлын байранд
C09	Амьсгалах эрхтэнг хамгаалах хэрэгслийг хэрэглэ		Хими биологийн хорт бодистой болон агаар хүрэлцээгүй нөхцөлд ажилладаг ажлын байр талбайд

C10	Ажлын өмнө салга		Өндөр хүчдэлээр ажилладаг цахилгаан суурь машин, цахилгааны самбарын дэргэд
C11	Гараа угаа		Гар бохирдсоноос эрүүл мэндэд хор хөнөөл учирч болзошгүй ажлын байранд
C12	Тамхи татах байр		Олон нийтийн газар болон албан газарт тамхи татах тусгай байрны дотор гадна талд
C13	Дуут дохио өг		Үзэгдэх орчин муутай газар орчин, үйлдвэрлэлийн байранд байрлуулна.
C14	Амны хаалт (ариун цэврийн) зүү		Онцгой цэвэр байдлыг шаарддаг ажлын байр, лабораторийн дотор болон хүн ихээр цугладаг эмнэлэг, олон нийтийн газар
Дөрөв		ЗААХ ТЭМДЭГ	
T01	Түргэн тусламж дуудах телефон утас		Автомат телефон утас, байгууллагуудын жижүүр, харуулын телефон утасны дэргэд, түүнд хүрэх замд T02 тэмдгийн хамт байрлуулна.
T02	Чиг заах тэмдэг		Телефон утас, эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх объектууд байгаа газрын ойр нэмэлт тэмдгийн хамт байрлуулна.
T03	Цугларах байр		Аваар осол гарсан үед хүмүүсийн цугларах байрны гадна болон цугларах байрны гадна болон цугларах байрны ойролцоо T02 тэмдгийн хамт байрлуулна.
T04	Анхан шатны тусламжийн эмийн сан		Анхан шатны тусламжийн эмийн сан байгаа байр, хадгалдаг савны дээр
T05	Эмчийн өрөө		Эмчийн өрөөний гадна болон эмчийн өрөөний ойролцоо T02 тэмдгийн хамт байрлуулна.

T06	Шаардлагатай үед хэрэглэх душ		Хүний эрүүл мэндэд хортой тоосонцор, бохир орчинд ажиллагсадад зориулсан ариун цэврийн өрөө, душны гадна талд
T07	Аврах гарц		Аюул ослын үед хүмүүсийн гарах гарц, хаалган дээр
T08	Аврах гарцны байгаа чиглэл		Аврах гарц харагдахгүй байгаа гудам хонгилд
T09	Аврах гарц уруу шатаар бууж оч		Аврах гарц харагдахгүй байгаа гудам хонгилд
T10	Аврах гарц дээр байна		Аврах гарц харагдахгүй байгаа гудам хонгилд
T11	Аврах гарц уруу тахир дутуу хүний очих зам		Аврах гарц харагдахгүй байгаа гудам хонгилд
T12	Аврах гарц уруу очих шат		Аврах гарц уруу очих шатны дэргэд байрлуулна.
T13	Нүдээ угаа		Хүний нүдэнд хортой тоосонцор, хэт хурц гэрэлтэй болон хортой орчноос гарах хаалганы дэргэд
G01	Галын хор		Галын хор байгаа газарт, галын хор харагдахгүй газарт G03 тэмдгийн хамт
G02	Галын крант		Гал унтраах хоолой байгаа газарт, түүний ойр орчимд G03 тэмдгийн хамт
G03	Чиг заах тэмдэг		Гал унтраах хэрэгслүүд байгаа газрын орчимд нэмэлт тэмдгийн хамт хэрэглэнэ.

Г04	Гал гарсныг мэдээлэх телефон утас		Автомат телефон утас, байгууллагуудын жижүүр, харуулын телефон утасны дэргэд, түүнд хүрэх замд Т02 тэмдгийн хамт байрлуулна.
Г05	Гал унтраах хэрэгслүүд		Гал унтраах хэрэгслүүд, галын хор, галын хөөсний хоолой байгаа газарт

6 Аюулгүй байдлын дохионы өнгө, зориулалт

6.1 Аюулгүй байдлын дохионы өнгө нь улаан, шар, ногоон, хөх дөрвөн өнгөтэй байна. Өнгө, тэмдэглэгээний агуулга, утга санаа 5-р хүснэгтэд заасан шаардлагад нийцэж байна.

Хүснэгт 5

Өнгө, тэмдэглэгээний агуулга, утга санаа

№	Дохионы өнгө	Дохионы өнгөний утга, хэрэглэх хүрээ	Тодруулах өнгө
1	УЛААН	Хориглох өнгө. Шууд аюул учруулах байдал, гал унтраах хэрэгсэлд хэрэглэнэ.	ЦАГААН
2	ШАР	Анхааруулах өнгө. Аюул учирч болзошгүй байдалд хэрэглэнэ.	ХАР
3	НОГООН	Заах өнгө. Аюулгүй байдлыг илэрхийлнэ.	ЦАГААН
4	ХӨХ	Сануулах, мэдээлэх өнгө	ЦАГААН

Тайлбар: Цагаан өнгийг тодруулах өнгө нь хар, хар өнгийг тодруулах өнгө нь цагаан болно.

6.2 Аюулгүй байдлын тэмдэг дээрхи тайлбар бичиглэл, дүрслэлийг 5-р хүснэгтэд заасан өнгөөр гүйцэтгэх ба хүрээг өнгөөр тодруулна.

6.3 Галын аюулгүй байр, галын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тэмдэгийг улаан өнгөөр илэрхийлнэ. Нэмэлт тайлбар бичгийг цагаан дэвсгэр дээр улаан өнгөөр хийсэн байна.

6.4 Улаан өнгө нь дараах зүйлд хэрэглэгдэнэ. Үүнд:

1. Хориглох тэмдгүүд
2. Галын аюулгүй тэмдгүүд
3. Машин механизмын хөдөлгөөнт эд ангийг хамгаалах нээгддэг бүрхүүлийн дотор тал болон тэдгээрийн таглаа
4. Машин механизмын хүчдэлээс салгах аваарын болон ердийн салгуур
5. Ажлын байдалд байгаа хүчдэл бүхий салгуурын гэр
6. Галын дараах төрлийн техник. Үүнд:
 - Гал унтраах хоолой болон гал унтраах автомат

төхөөрөмжийг ажиллуулах шахуурга

- Гал унтраах төхөөрөмжийг ажиллуулах байгууламж
- Утаа сорогч
- Ус түгээгүүрийн хоолойн эргүүлэн хаалт, гидрант-ус түгээгүүрийн газрын дээрх хэсэг, өндөр даралтат хөөсний генератор, лафетийн дөл, газар доорх гидрантын таг зэрэг гал унтраах тоног төхөөрөмж
- Галын мэдээллийн гар асаагуур бүхий хэрэгсэл
- Галын унтраагуур болон гал унтраах төхөөрөмж
- Хувин, сав, элсний хайрцаг зэрэг галын эд аж ахуй
- Хүрз, дэгээ зэрэг гал унтраах багажны модон бариул
- Аюулгүй ажиллагаа зөрчигдсөн тухай мэдээлэх дохионы чийдэн
- Гал унтраах багаж хэрэгсэл, гал унтраагуурыг байрлуулж бэхлэхэд зориулагдсан самбарын хүрээ. Самбар нь цагаан өнгөтэй, 30-100 см өргөнтэй улаан хүрээтэй байна.

- 6.5 Аюулгүй байдлын шаардлагын үүднээс будах шаардлагагүй тоног төхөөрөмж, эд аж ахуйн зүйлсийг улаан өнгөөр будахыг хориглоно.
- 6.6 Машин механизмын хөдөлгөөнт эд анги нь ашиглалтын явцад болон техникийн үйлчилгээ, засвар хийх үед бүр мөсөн авагддаг бүрхүүлтэй тохиолдолд тэдгээрийг болон тэдгээрийн хажуу талын үл хөдлөх эд ангийг улаан өнгөөр заавал будсан байх ёстой.
- 6.7 Гадны хүн орохыг хориглосон, аюултай бүсийг хязгаарласан зааг, нээлхий, нүх зэргийн эргэн тойронд түр хугацааны хаалт буюу аюулгүйн тууз байрлуулна. Аюулгүйн туузыг 60-110 мм-ийн өргөнтэй улаан, цагаан өнгөөр дараалуулан 46°-60°-ийн налуутайгаар будсан байна. /1-дүгээр зургийг үз/ Улаан, цагаан өнгөний харьцаа нь 1:1 байх ба туузны өргөн нь 50-100 мм хэмжээтэй байна.



1-р зураг. Аюулгүйн тууз

6.8 Дохионы шар өнгийг дараах зүйлд хэрэглэнэ. Үүнд:

1. Анхааруулах тэмдгүүд
2. Ажиллагсдад гэмтэл учруулахад шалтгаан болж болзошгүй барилгын хийцийн хэсэг эд, анги. Үүнд: шалны гадарга дээрхи овон товон, бага өндөрт байрлуулсан хөндлөвч дамнуур, ирмэг, налуу, нарийссан гарц, харагдалт муутай шат гишгүүр, худаг, мөн үйлдвэрлэлийн дотоод тээврийн эрчимтэй хөдөлгөөнтэй хэсэгт байгаа зогсоол, тулгуур багана зэрэг болно.
3. Болгоомжгүй хандснаас ажиллагсдад аюул учруулж болох үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эд ангиуд. Үүнд: Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хөдөлгөөнт эд ангиуд, тоног төхөөрөмжийн хөдөлгөөнтэй эд ангиудыг гүйцэд бус хаасан хамгаалах байгууламжийн ирмэг, пресс, хэв цохигчийн ирмэг, алхны хажуу тал, өндөрт гүйцэтгэх ажилд зориулагдсан талбай болон ажлын байрны орон зай эзлэж байгаа хана, таазанд байнга байдаг технологийн арматурыг хамгаалах хийц.

4. Цехийн дотоодын болон цех хоорондын тээврийн хэрэгсэл, эргэх, тээвэрлэх тоног төхөөрөмж болон зам барилгын машин эд анги, өргүүрийн хаалт болон кабин, эргэдэг кабин, ачаа өргөгчийн талбай, цахилгаан тэргэнцэрийн хажуу гадарга, ачаа ачигч, тэрэг экскаватор, байшин кран, авто болон монтажны карны эргэх тавцангийн доод хэсгийн сум, авто ачигчийн баригч болон талбай, экскаваторын шанаганы хажуу ханын гадна хэсэг, ачааны дэгээний дамрын халхавч.
 5. Аюултай бүсийг хязгаарласан зааг, нээлхий, нүх зэргийн дэргэд байрлуулсан байнгын ба түр хугацааны хаалт буюу түүний эд анги, шат барьж байгаа барилга, тавцан болон өндрөөс унаж болзошгүй аюултай бусад орчныг хаасан байнгын болон түр хугацааны хаалт, хашлага.
 6. Угсралтын хөдөлгөөнт байгууламж буюу тэдгээрийн эд анги болон ачаа барих хэрэгслийн эд анги, өргөгч цахилгаан шатны хөдөлгөөнт хэсэг.
 7. Аюултай болон хортой бодис агуулсан сав /савны эзэлхүүнээс хамааруулж 50-100 мм өргөнтэй шулуун зураасаар эргэн тойронд хүрээлэн анхааруулах өнгөөр будна/
 8. Аюулаас нүүлгэн шилжүүлэх болон нөөц гарцанд хүрэх хил хязгаар. Энэ хил хязгаарыг тогтоц сайтай арилдаггүй шар буюу цагаан өнгийн будгаар шалны гадарга дээр 50-100 мм өргөн зураас тавьж тэмдэглэнэ.
- 6.9 Энэхүү стандартын 3.9-ын “б”, “г”-д заасан үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хөдөлгөөнтэй, нээлттэй хэсгээс бусад объект, эд ангийг 30-200 мм-ийн өргөнтэй шар, хар өнгөөр дараалуулан 46°-60°-ийн налуутайгаар будсан байна. /2-дугаар зургийг үз/ Шар хар өнгөний харьцаа 1:1 байна. Өргөн нь будах объектын хэмжээ, анхааруулах будаг харагдах зайнаас хамаарна.



2-р зураг. Анхааруулах тууз

6.10 Дохионы ногоон өнгийг дараах зүйлд хэрэглэнэ.

- 6.10.1 Эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх, эрүүл ахуйн холбогдолтой заах тэмдэгүүд
- 6.10.2 Аюулаас нүүлгэн шилжүүлэх ба нөөц гарцын хаалга болон түүнд хүрэх чиглэлийг заах тэмдэгтүүд, гарцын дохионы чийдэн, гэрэлт самбарт.

6.11 Дохионы хөх өнгийг дараах зүйлд хэрэглэнэ.

6.11.1 Сануулах тэмдэгүүд

ТӨГСӨВ.